

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын ...-ны өдөр

№ ...

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дугаар зүйлийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1.“Журам батлах тухай” 2014 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 52 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам”-д дор дурдсан агуулгатай дараах заалтуудыг тус тус нэмсүгэй.

1/ “1.4.Хөгжлийн бодлогын баримт бичигт туссан хөгжлийн төслийг шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхэд дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдад нээлттэй санал хүргүүлэх, боломжит хөрөнгө оруулагчийг урьдчилсан байдлаар сонгон шалгаруулах арга хэмжээг журмын 1^{1.1}-д заасан Ажлын хэсэг зохион байгуулж болно.”

2/ Журмын бүлэгт 1 дүгээр бүлэг “Нийтлэг үндэслэл” гэсэн бүлгийн дараа “1¹.Хөгжлийн төслийн хөрөнгө оруулалтын бэлтгэл арга хэмжээ”

“1^{1.1}.Журмын 1.4-т заасан хөгжлийн бодлогын баримт бичигт туссан хөгжлийн төслийг шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхэд Засгийн газрын эрх олгосон холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулсан Ажлын хэсэг байгуулна.”

“1^{1.2}.Журмын 1^{1.1}-д заасан Ажлын хэсэг нь хөгжлийн төслийн цар хүрээ, онцлог, хэрэгцээ шаардлага, бэлэн байдлын зэрэг нөхцөл байдалд тулгуурлан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид санал хүргүүлж, ирүүлсэн саналыг судлан хамгийн ашигтай гэж үзэхүйц 5 хүртэлх оролцогч этгээд, Хөрөнгө оруулагчдын саналын хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, хэлэлцүүлнэ.”

“1^{1.3}.Төслийн цар хүрээ, онцлог, хэрэгцээ шаардлага, бусад шаардлагатай нөхцөл байдлыг харгалзан боломжит хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, урьдчилан яриа хэлэлцээ хийх, журмын 2.1-д заасан Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах хүртэл хугацаанд хөрөнгө оруулагчтай зөвшилцөх хүрээ хязгаарыг Засгийн газар тогтооно.”

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР